



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/46

Улаанбаатар хот

Ажлын хэсэг томилох тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.3, 30 дугаар зүйлийн 30.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Онцгой байдлын газрын даргын 2018 оны "Аргачлал заавар батлах тухай" А/372 дугаар тушаал, нийслэлийн Онцгой байдлын газрын дүрмийн 2.6, нийслэлийн Онцгой байдлын газрын даргын 2018 оны "Журам батлах тухай" А/18 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн удирдлага зохион байгуулалт, Гал түймэр унтраах, аврах ангиудын үйл ажиллагааг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөх ажлыг 2019 оны 05 дугаар сарын 10-14-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Хан-Уул дүүргийн ажлыг шалгах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, шалгах ажлын удирдамжийг хоёрдугаар, шаардагдах зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.


3. Шалгалт зохион байгуулахад шаардагдах 120.000 (нэг зуун хорин мянган) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.

4. Шалгалтыг батлагдсан удирдамжийн дагуу явуулж, дүнг 2019 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (дэд хурандаа Б.Мягмардорж)-д үүрэг болгосугай.

ДАРГА,
ХУРАНДАА  Ж.ЧҮЛТЭМСҮРЭН



Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн
А/Х/Б дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Мягмардорж Газрын дэд дарга бөгөөд Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа,

Гишүүд:

Ж.Төмөрмандах Дотоод, хяналт шинжилгээ, үнэлгээ, эрсдэлийн удирдлагын тасгийн дарга, хошууч,

С.Содонтуяа Захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн, дэд хурандаа,

Ц.Чинзориг Дотоод, хяналт шинжилгээ, үнэлгээ, эрсдэлийн удирдлагын тасгийн ахлах мэргэжилтэн, ахмад,

Ч.Батболд Дотоод, хяналт шинжилгээ, үнэлгээ, эрсдэлийн удирдлагын тасгийн мэргэжилтэн, ахмад,

Нарийн бичиг:

Ө.Мөнх-Отгон Захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн, дэслэгч

---o0o---

НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ШАЛГАЖ, ҮНЭЛЭЛТ ДҮГНЭЛТ ӨГӨХ АЖЛЫН УДИРДАМЖ

Зорилго: Нийслэлийн Онцгой байдлын газрын Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн алба хаагчдын удирдлага зохион байгуулалт, сахилга, дэг журам, цэрэгжилт жагсаалч байдал, ёс зүйг сайжруулахад чиглэгдэнэ.

Хэрэгжих хугацаа: 2019 оны 05 дугаар сарын 10-14-ний өдөр хүртэл.

НЭГ. Хамрах хүрээ

Нийслэлийн онцгой байдлын газрын Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтэс, гал түймэр унтраах, аврах 14, 30, 65 дугаар ангиуд хамрагдана.

ХОЁР. Зохион байгуулах ажлын чиглэл


Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтэст дараах чиглэлийн ажлыг зохион байгуулна. Үүнд:

- Цаг ашиглалт, томилгоот ээлж, жижүүр, харуулын үүрэг гүйцэтгэл,
- Зэвсэгт Хүчний Жанжин Штабын даргын 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/493 тушаалаар батлагдсан “Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм”-ийн хэрэгжилт,
- Алба хаагч нэг бүртэй ганцаарчилсан уулзалтыг зохион байгуулж, “Төрийн алба хаагчийн ёс зүй”-н хэм хэмжээний талаар ярилцах.

ГУРАВ. Удирдамжийн дүн, биелэлт

Удирдамжийн дүн, биелэлтийг 2019 оны 05 дугаар сарын 14-ний өдөр удирдлагад илтгэх хуудсаар танилцуулах.

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн
А/36 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



"НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ШАЛГАЖ, ҮНЭЛЭЛТ ДҮГНЭЛТ ӨГӨХ" АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ШАТАХУУНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

2019 ОНЫ 05 ДУГААР САРЫН 10-11-НИЙ ӨДРҮҮДЭД

№	Явах маршрут	км
1	НОБГ - ХУД-н ГТУА 30-р анги	21км
2	ХУД-н ОБХ-н ГТУА 30-р анги – ХУД-н ОБХ-н ГТУА 65-р анги	28км
3	ХУД-н ОБХ-н ГТУА 65-р анги - ХУД-н ОБХ-н ГТУА 30-р анги	28км
4	ХУД-н ОБХ-н ГТУА 30-р анги – НОБГ	21км
5	НОБГ - ХУД-н ОБХ-н ГТУА 14-р анги	6км
6	ХУД-н ОБХ-н ГТУА 14-р анги- ХУД-н ОБХ-н ГТУА 30-р анги	19км
7	ХУД-н ОБХ-н ГТУА 30-р анги- ХУД-н ОБХ-н ГТУА 65-р анги	28км
8	ХУД-н ОБХ-н ГТУА 65-р анги- ХУД-н ОБХ-н ГТУА 30-р анги	28км
9	ХУД-н ОБХ-н ГТУА 30-р анги- ХУД-н ОБХ-н ГТУА 65-р анги	28км
10	ХУД-н ОБХ-н ГТУА 65-р анги - НОБГ	46км
	Нийт	253 км

Жич: Зардлын тооцоог Старекс маркийн автомашинаар тооцсон болно. Уг автомашин нь 100км - 14литр шатахуун зарцуулна. 1л=1860төгрөг
Шаардагдах зардал: 253км х 35,4л х 1860 = 65.837 төгрөг

2019 ОНЫ 05 ДУГААР САРЫН 13-14-НИЙ ӨДРҮҮДЭД

№	Явах маршрут	км
1	НОБГ - ХУД-н ГТУА 14-р анги	6км
2	ХУД-н ОБХ-н ГТУА 14-р анги – ХУД-н ОБХ-н ГТУА 65-р анги	47км
3	ХУД-н ОБХ-н ГТУА 65-р анги - ХУД-н ОБХ-н ГТУА 30-р анги	28км
4	ХУД-н ОБХ-н ГТУА 30-р анги – ХУД-н ОБХ-н ГТУА 65-р анги	28км
5	ХУД-н ОБХ-н ГТУА 65-р анги - ХУД-н ОБХ-н ГТУА 30-р анги	28км
6	ХУД-н ОБХ-н ГТУА 30-р анги – ХУД-н ОБХ-н ГТУА 14-р анги	19км
7	ХУД-н ОБХ-н ГТУА 14-р анги - НОБГ	6км
8	НОБГ - ХУД-н ОБХ-н ГТУА 30-р анги	21км
9	ХУД-н ОБХ-н ГТУА 30-р анги- ХУД-н ОБХ-н ГТУА 14-р анги	19км
10	ХУД-н ОБХ-н ГТУА 14-р анги - НОБГ	6км
	Нийт	208 км

Жич: Зардлын тооцоог Старекс маркийн автомашинаар тооцсон болно. Уг автомашин нь 100км - 14литр шатахуун зарцуулна. 1л=1860төгрөг
Шаардагдах зардал: 208км х 29,12л х 1860 = 54.163 төгрөг

НИЙТ ШАТАХУУНЫ ЗАРДАЛ

№	ЯВСАН ӨДӨР	НИЙТ /төгрөг/
1	2019 ОНЫ 05 ДУГААР САРЫН 10-11-НИЙ ӨДРҮҮДЭД	65.837
2	2019 ОНЫ 05 ДУГААР САРЫН 13-14-НИЙ ӨДРҮҮДЭД	54.163
	НИЙТ	120.000